



**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН  
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 181/ШЗ2019/02030

Улаанбаатар хот

Г Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай Г

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Хишигбат би,

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, Ньюмайд групп ХХК-ийн байранд байрлах, “Лэндмн ББСБ” ХХК/РД: 5039754/-ийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бэлхийн 46 гудамж, 61 тоотод оршин суух, Дарханхан овгийн Буригдаагийн Амаржаргал/РД: ДЮ89111394/-д холбогдох,

254 451 төгрөгийг гаргуулах тухай иргэний хэргийг хянаад

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: “... нийт 254 451/хоёр зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун тавин нэг/ төгрөгийг гаргуулж өгнө үү.” гэжээ.

ҮНДЭСЛЭХ НЬ:

Нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХХК, хариуцагч Б.Амаржаргалд холбогдуулан 254 451 төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэлийг тус шүүхэд гаргажээ.

Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлд зааснаар хариуцагчийн хаягаар дуудаж, мэдэгдэх хуудас хүргүүлсэн боловч хариуцагч Б.Амаржаргал Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бэлхийн 46 гудамж, 61 тоот хаягт бүртгэлтэй боловч оршин сууддаггүй болох нь тус хорооны Засаг даргын тодорхойлолтоор тогтоогдож, шүүх хуулийн дээрх зүйлд заасан ажиллагааг хийж гүйцэтгэх боломжгүй болсон болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1-т “энэ хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.9-д заасан үндэслэл иргэний хэрэг үүсгэснээс хойш ... тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгоно” гэж заасан “Лэндмн ББСБ” ХХК-ийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, Б.Амаржаргалд холбогдуулан үүсгэсэн иргэний хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1, 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсэгт заасныг тус тус удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн

65.1.9 дэх заалтад зааснаар нэхэмжлэгч “Лэндмн ББСБ”-ийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, Б.Амаржаргалд холбогдуулан гаргасан 254 451 төгрөгийг гаргуулах тухай иргэний хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХХК-ийн 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 532.53 төгрөг, 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 7 751 төгрөгийг тус тус Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, орон нутгийн төсвийн орлогын 100200600941 тоот данснаас буцаан гаргуулан нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХХК-д буцаан олгосугай.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь энэ захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болохыг дурдсугай.

ШҮҮХЧ  С.ХИШИГБАТ